4. “Цариг шонхор” ХХК нь 2019 онд хайгуулын ажлыг Хайлаастын хөндийн доод хэсгийн баруун (хш-24-с хш-40), Зүүн борт хэсэг (хш-16-с хш-20, хш-721-с хш-726) дэх алтны шороон ордод 200х20 м-ийн торын нягтралаар, нийт хайгуулын 11 пугамын дагуу баруун (хш-24-с хш-40) байрших бага гүний дунджаар 7.7м, зүүн борт (хш-16-с хш-20, хш-721-с хш-726) байрших гүн нь дунджаар 39.7м байна. Нийт 38-н цооног буюу 678.4 т.м өрөмдлөгийн ажил хийсэн. Талбайд 1:2000-ны байрзүйн зураглалыг “Экситос” ХХК, алттай дээжийг үлээх, дэнслэх ажлын “Цариг шонхор” ХХК-ийн уурхайн лаборатори, сорьц тогтоох шинжилгээ, алтны хяналтын жигнэлт алтны шигшүүр шинжилгээ, технологийн туршилтыг Геологийн төв лаборатори гүйцэтгэсэн.

5. MV-000296 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт, металлогений хувьд Хойт Хэнтийн алтны бүсийн Заамарын хүдрийн дүүргийн зангилаан дахь Бумбатын хүдрийн талбайд оршино.

Геологийн тогтоцын хувьд Хайлааст хөндий нь Туул голын баруун гар талын томоохон цутгалын нэг бөгөөд Заамарын нурууны усан хагалбар дахь 1714.7м-ийн өндөрлөг бүхий Халзан уулсын өврөөс эх авч, баруун хойш чиглэлтэйгээр 300-800м хүртэл өргөнтэйгээр, 15.0 км урт үргэлжлэн улмаар Туул голын эртний хөндийн тэгшрэлийн гадаргуутай нийлдэг. Хөндий орчин үеийн голдирол (сайр) нь хөндийн төв болон зүүн эрэг дагууд 40-60 м өргөнтэй тэмдэглэгдэх ба уг голдирлын хэсэгт хуурай, зөвхөн дулааны улиралд хур тунадас элбэг үед түр зуурын гадаргын ус урсдаг. Хайгуул, олборлолт явуулсан шороон ордын хүрээнд хөндийн хэлбэр нь зарим хэсэгтээ өөрчлөгдөх бөгөөд эхэн хэсэгтээ 200-350м өргөнтэй U хэлбэрийн хавцал маягийн хөндлөн огтлолтой, түүнээс доош хөндий нь 560 м хүртэл огцом өргөсч, улмаар хөндийн адаг хэсэгт 800 м-г хүрч задгайран тэвш хэлбэрийн хөндлөн огтлолд шилжсэн байна. Хөндий нь зүүн хойд, баруун хойд чиглэлийн хагарлын бүсэд үүссэ, түүний баруун, зүүн эрэг дагууд, хөндийн ул суурь (ёроол) хэсэгт хүчтэй цахиуржсан эвдрэл, бутралын бүсүүд тэмдэглэгдэх ба эдгээр нь хайгуулын өрөмдлөг, геофизикийн судалгаагаар тогтоогдсон байна.

Хөндийн дагууд харьцангуй бага зайнд хөндийн хэлбэр, сэвсгэр хурдасны зузаан огцом өөрчлөгддөг нь хөндийн үүсэл удаан хугацаанд хэд хэдэн удаагийн тектоник хагаралын үйл явцад бий болж хөндий нь шаталсан (блоклог) тогтоцтой болсон байна. Дээрх хагарлуудын далайц, шилжилтийн өргөгдөл, суулгаар бий болсон элэгдлийн түвшинээр зарим геоморфологийн нэгж, түүнтэй холбоотой хурдас, хуримтлал хадгалагдаж, эсвэл зөөгдсөн. Хөндийн хоёр хажуу дагууд 350-2000 м хүртэл урттай цухуйц (цокол) дэнжүүд тэмдэглэгддэг.

Хайлаастын хөндийд тархсан сэвсгэр хурдас нь литологийн найрлага, насаараа ялгаатай саарал, улаан хүрэн, шар өнгийн өөр өөр хурдаснаас бүрдэнэ.

Саарал өнгийн хурдас нь зүсэлтийн дээд хэсэгт орших ба голоцен ( $Q_2$ )-ы, дээд плейстоцен-голоцен ( $Q_{1-2}$ )-ы настай. Улаан өнгийн хурдас нь зүсэлтийн дунд хэсэгт байрлах ба насны хувьд дээд плиоцен ( $N_2^2$ )-д, шар, шаравтар, улаавтар шар өнгийн хурдас нь зүсэлтийн доод хэсэгт байрлах бөгөөд насны хувьд доод плиоцен ( $N_2^1$ )-д тус тус хамаарна.

Голоцен ( $Q_2$ )-ы настай хурдасыг дотор нь гарал үүслээр нь голын ба бэл хормойн гэж хоёр хуваана. Голын гаралтай хурдас нь хөндийн татам болон орчин үеийн голын хуурай голдирол буюу жалгыг дагаж хуримтлагдсан бөгөөд хайрга, хайрганцарын хольцтой цайвар саарал өнгийн элсэрхэг хурдаснаас бүрджээ. Бэл хормойн гаралтай хурдас нь хөндийн хоёр хажууг даган, уулын бэлээр тархаж энгэр дэнж хэлбэрийн гадаргууг үүсгэнэ. Бэл хормойн хурдас нь чулуулгийн өнцөглөсөн хэмхдэс, том хэмжээний бул чулуу агуулсан цайвар саарал өнгийн шаварлаг-элсэрхэг хурдаснаас бүрдэнэ. Хурдасны зузаан нь 4.0-15.0 м-т хэлбэлзэх ба бэл хормойн гаралтай хурдсанд алтны агуулга тогтоогдоогүй.

Голоцен ( $Q_2$ )-ы настай голын гаралтай хурдас нь ерөнхийдөө цайвар саарал өнгөтэй боловч литологийн найрлагаараа хоёр хэсэгт хуваагдана.

Голоцен ( $Q_2$ )-ы настай, цайвар саарал өнгийн хайргархаг-элсэрхэг хурдас нь алттай дээд давхаргыг агуулах бөгөөд харин зүсэлтийн дээд хэсэгт байрлах шаварлаг-элсэрхэг хурдсанд алтны агуулга тогтоогдоогүй.

Дээд плейстоцен-голоцен ( $Q_{1-2}$ )-ы настай хурдас нь хөндийн дэнжийн хэсэгт тархах ба голын гаралтай хайргархаг элсэрхэг хурдаснаас бүрдэнэ. Энэ насны саарал өнгийн аллюви-проллювийн гаралтай хурдсанд ашигт дунд давхарга тогтоогдсон.

Дээд плиоцен ( $N_2^2$ )-ы настай улаан, улаан хүрэн өнгийн хурдас нь зүсэлтийн дунд хэсэгт байрлах ба чулуулгийн өнцөглөсөн хэмхдэс, ганц нэг мөлгөржсөн жижиг хайрга агуулсан, элсний хольцтой тоосгон улаан өнгийн шавраас бүрддэг. Энэхүү улаан өнгийн хурдсанд үйлдвэрлэлийн сонирхол татахуйц хэмжээний алтны хуримтлал тогтоогдоогүй.

Доод плиоцен ( $N_2^1$ )-ы настай хурдас нь шар, шаравтар, цайвар шаргал өнгийн эрчимтэй өгөршсөн, сайн мөлгөржсөн хайрга, хайрганцарын үеүүдийг агуулсан шавар, шавранцараас тогтох ба аллювийн гаралтай, 2.0-12.0 м зузаантай. Энэхүү хурдас нь кайнозойн үеийн алтны шороон үүслийн хуримтлалтай холбоотой бөгөөд Заамарын гүний дарагдмал шороон ордуудын доод ашигт давхаргыг агуулдаг байна.

6. Алт агуулсан элсний баяжуулах технологийн туршилтаар алтны мөхлөгүүдийн 62.78% нь  $-0.1+0.5$  мм-ийн ангилалд, 72.06% нь  $-0.5+0.5+0.25$  мм-ийн ангилалд, 5.44%  $-0.25+0.125$  мм-ийн ангилалд, 0.59% нь  $-0.125+0.063$  мм-ийн ангилалд, 0.09% нь  $-0.0063$  мм-ийн ангилалд тус тус хамарсан байна. Технологи туршилтаас гарсан нийт алтанд зэрэгцээ сорьц тогтоолгоход Геологийн төв лабораторид 860.87 гэж тодорхойлжээ. Элсний угаагдах чанар нь туршилтын эцсийн бүтээгдэхүүнд хийсэн балансын тооцоогоор 0.25%-ийн гарцтай, 92.6%-ийн металл авалттайгаар баяжуулан авч болохыг тогтоосон байна.

7. Зохиогчид 2019 оны нэмэлт хайгуулын ажлаар "Хайлааст" нэртэй MV-000296 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлааст хөндийн доод хэсгийн баруун (хш-24-с хш-40), Зүүн борт хэсэгт (хш-16-с хш-20, хш-721-с хш-726) нэмж тогтоосон геологийн нөөцийг бодитой (B) зэрэглэлээр шлихээр 58.06 кг-аар, химийн цэврээр 50.16 кг-аар, боломжтой (C) зэрэглэлээр шлихээр 7.45кг-аар, химийн цэврээр 6.42 кг-аар, нийт бодитой, боломжтой (B+C) зэрэглэлээр шлихээр 65.52 кг-аар, химийн цэврээр 56.58 кг-аар тус тус тооцсон байна.

Шинжээч дээрх нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж ордын геологийн нөөцийг зохиогчдын тооцоолсон хувилбараар ашигт малтмалын нэгдсэн тоо бүртгэлд авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед Зөвлөлийн гишүүдийн

олонхын саналаар ордын геологийн нөөцийг шинжээчийн санал болгосон зохиогчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх зүйтэй гэж үзэв.

8. Зохиогчид ордын нөөцийн тооцоонд дараах жишиг үзүүлэлтүүдийг авч хэрэглэсэн байна. Үүнд:

- Босоо алхам дахь ашигт давхаргын хил хүрээг тогтоох захын агуулга: - 100 мг/м<sup>3</sup>
- Ашигт давхаргын хамгийн бага зузаан: - 0.4 м
- Ашигт давхарга доторх ядуу агуулгатай хэсэг буюу хоосон хэсгийн хамгийн их зузаан: - 0.8 м
- Нөөцийн хэсэглэлийн хил хязгаарыг тогтоох захын малталтын хамгийн бага алтны агуулга: 228 мг/м<sup>3</sup> + 30 Кх (Кх - хөрс хуулалтын итгэлцүүр)
- Нөөцийн хэсэглэлийн хамгийн бага алтны агуулга-750 мг/м<sup>3</sup>
- Ашигт давхаргын хамгийн бага өргөн: - 20.0 м

9. Ордын талбай нь Монгол орны гидрогеологийн ангиллаар Хангай, Хэнтийн гидрогеологийн мужид, гидрогеологийн дүүрэгчлэлээр Туул голын ай савд хамаарна.

10. Хайгуулын ажлаар тогтоогдсон геологийн нөөцөнд үндэслэн ашиглалтын үеийн элсний хаягдалыг 1.0%, технологийн хаягдалыг 18%, үйлдвэрлэлийн нөөцийг химийн цэврээр 50.53 кг-аар тооцсон байна. ТЭЗҮ-ийн урьдчилсан тооцоогоор ашиглалтын нөөцөөр 2246.47 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 107.43 мян.м<sup>3</sup> элс олборлон угааж, химийн цэврээр 50.53 кг алт борлуулахад, борлуулалтын орлого 6958.54 сая төгрөг, үйлдвэрлэлийн нийт зардал 5646.85 сая төгрөг, нийт цэвэр ашиг 1170.52 сая төгрөг болох ба бэлэн мөнгөний урсгал 2211.17 сая төгрөг болно. 1 гр алтыг олборлох бүрэн өөрийн өртөг нь 111747 төгрөг байна. Байгаль орчин хамгаалах ажлын зардалд 6.53 сая төгрөг, хаалт нөхөн сэргээлтийн ажлын нийт зардалд 305.99 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

11. Цаашид техник-эдийн засгийн үнэлгээг боловсруулахдаа байгаль орчны үнэлгээнүүд, ТЭЗҮ-ийг эрх бүхий байгууллагаар үндэслэлтэй боловсруулах, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг төлөвлөгөөний дагуу хийх, үүсмэл орд байх боломжтой тул ашиглалтын үед нэмэлт хайгуул хийх, өмнөх олборлолтын овоолго ашиглалтын үед нурах магадлалтай болохыг анхаарч геотехникийн шинж чанарыг судлах, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

*Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ, АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг АМГТГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:*

Нэг. Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлааст хөндийн доод хэсгийн баруун (хш-24-с хш-40), Зүүн борт хэсэгт (хш-16-с хш-20, хш-721-с хш-726) 2019 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайлан (2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар) дахь алтны шороон ордын нөөцийг бодитой (В) зэрэглэлээр шлихээр 58.06кг-аар, химийн цэврээр 50.16 кг-аар, боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 7.45 кг-аар, химийн цэврээр 6.42 кг-аар, нийт бодитой болон боломжтой нөөцийг (В+С) зэрэглэлээр шлихээр 65.52 кг-аар, химийн цэврээр 56.58 кг-аар энэхүү дүгнэлтийн хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан алтны шороон ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх.

Гурав. Энэхүү дүгнэлтийн 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Цариг шонхор” ХХК (Б.Буянхишиг)-д анхааруулах.

Дөрөв. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Цариг шонхор” ХХК (Б.Буянхишиг)-д даалгах.

Тав. Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хайлааст хөндийн доод хэсгийн баруун (хш-24-с хш-40), Зүүн борт хэсэгт (хш-16-с хш-20, хш-721-с хш-726) 2019 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн боловсруулалт, түүний бүх төрлийн дээжлэлтийг геологич Л.Долгорсүрэн, геологич С.Энхтуяа, геологич Х.Баасанхүү, уулын инженер Б.Буянхишиг нар, лабораторийн шинжилгээг Геологийн төв лаборатори, 1:2000-ны масштабтай байрзүйн зураглалын ажлыг “Экситос” ХХК тус тус хариуцах, тайлан, түүн дэх нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг шинжээч МУ-ын мэргэшсэн инженер, геологич Б.Батнасан, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Цариг шонхор” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2021 оны 01 дугаар сарын 15

№ Т/21-01-10.

Улаанбаатар хот

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296 болон MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Хайлаастын алтны шороон ордын Доод (хш-720-722, 14-16), Дэнжийн (хш-47-57) хэсэг, Хайлаастын хөндийн Жалга-3, Жалга-4, Хайлаастын алтны шороон ордын 36-38-р шугамд байрлах 2017 онд гүйцэтгэсэн 0-4-р шугам хоорондох алтны үүсмэл шороон орд, Хайлааст хөндийн Доод хэсгийн баруун (хш-24-40), зүүн борт хэсгийн (хш-16-20, хш-721-726) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг хэлэлцсэн тухай

“Ирмүүн босго” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК-ийн боловсруулсан Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296 болон MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Хайлаастын алтны шороон ордын Доод (хш-720-722, 14-16), Дэнжийн (хш-47-57) хэсэг, Хайлаастын хөндийн Жалга-3, Жалга-4, Хайлаастын алтны шороон ордын 36-38-р шугамд байрлах 2017 онд гүйцэтгэсэн 0-4-р шугам хоорондох алтны үүсмэл шороон орд, Хайлааст хөндийн Доод хэсгийн баруун (хш-24-40), зүүн борт хэсгийн (хш-16-20, хш-721-726) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Б.Магванжав шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1 нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1 нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг



хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1 нь Төслийн ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн хэмжээсүүд, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Уурхайн угаан баяжуулалтын хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин нөхөн сэргээлт хаалт, Төслийн эдийн засаг зэрэг 10 бүлэг, Дүгнэлт, Хавсралт материал бүхий 174 хуудас тайлбар бичиг, 14 хавсралт зургаас бүрдэж байна.

4. MV-019638 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Хайлаастын хөндийн Жалга-3, Жалга-4 алтны шороон ордын нөөцийг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлын ХХ-05-03 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн н/72 дугаар тушаалаар ордын нөөц нь химийн цэврээр нийт (В+С) зэрэглэлээр 15.95 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Үүнээс (В+С) зэрэглэлээр химийн цэврээр 7.82 кг алтны үлдэгдэл нөөц байна.

MV-000296 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Хайлаастын алтны шороон ордын Доод (хш-720-722, 14-16), Дэнжийн (хш-47-57) хэсэг алтны шороон ордын нөөцийг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хурлын ХХ-11-12 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн н-124 дүгээр тушаалаар ордын нөөц нь эдийн засгийн үр ашигтай химийн цэврээр нийт (В+С) зэрэглэлээр 90.66 кг, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай химийн цэврээр нийт (В+С) зэрэглэлээр 28.02 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Үүнээс тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай (В+С) зэрэглэлээр химийн цэврээр 0.28 кг алтны үлдэгдэл нөөц байна.

MV-000296 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Хайлаастын алтны шороон ордын 36-38-р шугамд байрлах 2017 онд гүйцэтгэсэн 0-4-р шугам хоорондох алтны үүсмэл шороон ордын нөөцийг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлын ХХ-07-11 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн н/61 дүгээр тушаалаар ордын нөөц химийн цэврээр С зэрэглэлээр 18.26 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Үүнээс С зэрэглэлээр химийн цэврээр 1.03 кг алтны үлдэгдэл нөөц байна.

MV-000296 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Доод хэсгийн баруун (хш-24-40), зүүн борт хэсгийн (хш-16-20, хш-721-726) алтны шороон ордын нөөцийг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хурлын ХХ-09-10 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТГ-ын даргын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн н/102 дугаар тушаалаар ордын нөөц химийн цэврээр (В+С) зэрэглэлээр 56.58 кг гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд ашиглалтын үеийн хаягдалгүй, зөвхөн бохирдол үүсгэн олборлохоор тооцсон байна. Ашиглалтын үеийн бохирдол 22.77% буюу 28.94 мян.м<sup>3</sup> байхаар тооцож, геологийн бодитой В болон боломжтой С зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор 148.18 мян.м<sup>3</sup> элс буюу химийн цэврээр 57.37 кг алтны нөөцтэй байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 2,633.12 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 103.0 мян.м<sup>3</sup> элс олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 2 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй, дотоод, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд  $5.4 \text{ м}^3$  утгуурын багтаамжтай Hyundai R850LC маркийн экскаватор,  $3.2 \text{ м}^3$  утгуурын багтаамжтай Hyundai R520LC маркийн экскаватор, 50 тн даацтай Howo 371 маркийн автосамосвал,  $6.8 \text{ м}^3$  хусуурын багтаамжтай CAT D8 маркийн бульдозер,  $3.3 \text{ м}^3$  хусуурын багтаамжтай Shantui SD16 маркийн бульдозер,  $3.0 \text{ м}^3$  утгуурын багтаамжтай SDLG953 маркийн дугуйт ачигч, СБ-80 маркийн угаах төхөөрөмж зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тусгажээ.

8. Угаан баяжуулах хэсгийн баяжуулах технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон "Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын Технологи туршилтын лабораторид хийлгэсэн технологи туршилтын тайланд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Угаан баяжуулах хэсгийн хүчин чадал  $103.0 \text{ мян. м}^3/\text{жил}$  байна.

9. Шигшүүрийн шинжилгээгээр  $-1+0.5$  мм-ийн ангилалд нийт алтны 44.54%,  $-0.5+0.25$  мм-ийн ангилалд 51.12%,  $-0.25+0.125$  мм-ийн ангилалд 3.86%,  $-0.125+0.063$  мм-ийн ангилалд 0.42%,  $-0.063$  мм-ийн ангилалд 0.06% тус тус ноогдож байна гэж үзжээ.

10. Технологи туршилтын ажлыг гравитацийн аргаар хийж гүйцэтгэжээ. Үүний үр дүнд 0.25%-ийн гарцтай, 92.6%-ийн металл авалттай баяжмал гарган авч болохыг тогтоосон байна. Баяжуулалтаас нийт 140.96 мг алт ялган авсан бөгөөд алтны дундаж агуулгыг тооцон үзэхэд  $490.2 \text{ мг/м}^3$  байсан байна. Угаан баяжуулах хэсэг нь төслийн нийт хугацаанд 61.17 кг шлихийн алт, химийн цэврээр 53.14 кг алт үйлдвэрлэнэ.

11. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Төв аймгийн Заамар сумын нутагт орших ДСЦТС-110 кВ-ын шугамнаас салбарласан 35 кВ-ын Баянгол дэд станцаас 6 кВ-ын агаарын шугам татан 0.4 кВт-ын хүчдэлтэй, 630 кВа-ын суурилагдсан хүчин чадалтай хаалттай дэд станц угсран цахилгаан эрчим хүчээр хангахаар тооцоолжээ.

12. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 468.94 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 17.00 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 142.03 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 240.09 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 56.16 сая төгрөг, хаалтын дараах хяналтын зардалд 13.66 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ. Техникийн нөхөн сэргээлтийн зарим ажил хөрс хуулалтын ажлын зардалд тооцоологдсон байна.

13. Уг төслийг хэрэгжүүлснээр 71 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1.5 сая төгрөг байхаар байна.

14. Хайлаастын алтны шороон ордын Доод (хш-720-722, 14-16), Дэнжийн (хш-47-57) хэсэг, Хайлаастын хөндийн Жалга-3, Жалга-4, Хайлаастын алтны шороон ордын 36-38-р шугамд байрлах 2017 онд гүйцэтгэсэн 0-4-р шугам хоорондох алтны үүсмэл шороон орд, Хайлааст хөндийн Доод хэсгийн баруун (хш-24-40), зүүн борт хэсгийн (хш-16-20, хш-721-726) алтны шороон ордыг ашиглах ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 4.25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс биет бус хөрөнгө оруулалт 110 сая төгрөг, ил уурхайн болон баяжуулахын үндсэн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 3.9 тэрбум төгрөг, дэд

бүтцийн хөрөнгө оруулалт 70.2 сая төгрөг, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 130.7 сая төгрөг, бусад хөрөнгө оруулалт 33.7 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд дунджаар 747.6 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

15. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 7.51 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 8.72 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 1.2 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 2.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 141,394 төгрөг/гр байна.

16. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 2.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @8%) 0.44 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 25 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.7 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл хэрэгжүүлэгчид, УУХҮЯ-ны сайд, БОАЖЯ-ны сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдэрийг нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг батлуулан хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг журмын дагуу хийх,
2. Уурхайн хажуугийн тогтворжилтын асуудал болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тал дээр анхаарах,
3. Олборлосон алтаа Монгол банкинд “Ирмүүнбосго” ХХК-ийн нэр дээр тушаах шаардлагатайг ЭБМЗ-өөс даалгаж байна.
4. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Б.Магванжав тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. “Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296 болон MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Хайлаастын алтны шороон ордын Доод (хш-720-722, 14-16), Дэнжийн (хш-47-57) хэсэг, Хайлаастын хөндийн Жалга-3, Жалга-4, Хайлаастын алтны шороон ордын 36-38-р шугамд байрлах 2017 онд гүйцэтгэсэн 0-4-р шугам хоорондох алтны үүсмэл шороон орд, Хайлааст хөндийн Доод хэсгийн баруун (хш-24-40), зүүн борт хэсгийн (хш-16-20, хш-721-726) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1”-ийг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д дахин тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296 болон MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Хайлаастын алтны шороон ордын Доод (хш-720-722, 14-16), Дэнжийн (хш-47-57) хэсэг, Хайлаастын хөндийн Жалга-3, Жалга-4, Хайлаастын алтны шороон ордын 36-38-р шугамд байрлах 2017 онд гүйцэтгэсэн 0-4-р шугам хоорондох алтны үүсмэл шороон орд, Хайлааст хөндийн Доод хэсгийн баруун (хш-24-40), зүүн борт хэсгийн (хш-16-20, хш-721-726) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ





Нийт ордын хэмжээнд (С)	30.83	14.3	1.7	299.30	111.40	155	17.27	15.32	74.43	82	5.58	183.87	32.93	155	8.99
Нийт ордын хэмжээнд (В)	79.73	17.0	1.3	1,275.17	100.21	665	66.65	57.86	-	-	-	1,107.41	94.15	665	56.72
Нийт ордын хэмжээнд (В+С)	110.56	13.8	1.4	1,574.47	211.61	397	83.92	73.18	74.43	82	5.58	1,291.27	127.07	397	65.72

Хайгуулын ажлаар тогтоогдсон Геологийн бодитой (В) боломжтой (С) зэрэглэлийн нөөцөд тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайдын 201 (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан алтны шороон ордод хаягдалгүй ашиглалт явуулахын тулд алттай элсний давхаргаас дээ олборлолтонд хамруулахаар тооцсон. Мөн уурхайн хажуугаас элсийг бохирдуулахаар тоо олборлоно.

2020 оны 07-р сарын 01 өдрийн ЭБМЗ-ын ХХ-09-10 тоот дүгнэлтийн дагуу батлагдсан нөөцийн нөөцтэй 1-С, 2-В, 3-С блокуудад хэсэгчилж давхцсан тул 1-С блокоос 2.46 мян.м<sup>2</sup> талбай, 167.76 мян.м<sup>3</sup> хөрс, 6.06 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 1.14 кг алт, 3-С блокоос 0.50 мян.м<sup>2</sup> талбай, В+С зэрэглэлээр 7.62 мян.м<sup>2</sup> талбай, 277.61 мян.м<sup>3</sup> хөрс, 10.10 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 1.14 кг алт.

Жич: 2020 оны 07-р сарын 01 өдрийн ЭБМЗ-ын ХХ-09-10 тоот дүгнэлтэнд давхцсан нөөцийн нөөцтэй 1-С, 2-В, 3-С блокуудад хэсэгчилж давхцсан тул 1-С блокоос 2.46 мян.м<sup>2</sup> талбай, 167.76 мян.м<sup>3</sup> хөрс, 6.06 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 1.14 кг алт, 3-С блокоос 0.50 мян.м<sup>2</sup> талбай, В+С зэрэглэлээр 7.62 мян.м<sup>2</sup> талбай, 277.61 мян.м<sup>3</sup> хөрс, 10.10 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 1.14 кг алт.

Үзүүлэлт гаргасан:

"Цариг Ресурс" ХХК-ийн  
Уулын инженер. / А.Эрдэнэбуураг /



15	1.47	0.17	0.07	0.06	18.42	14.3	1.7	182.39	32.76	312	10.23	8.93	34.99	11.52		648.30	830.70	44.28	231	10.23	8.93
84	203.04	7.66	9.57	8.29	70.23	17.0	1.3	904.36	86.48	645	55.81	48.44	18.50	17.41		898.06	1,802.42	103.90	537	55.81	48.44
99	204.51	7.83	9.64	8.35	88.65	13.8	1.4	1,086.7	119.24	554	66.05	57.37	22.77	28.94	Нийт (В)	1,546.32	3,263.12	148.18	446	66.05	57.37

тулгуурлан ордыг ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулсан уурхайн хил хязгаар дотор орших бохирдол оны 9-р сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу (В+С) зэрэглэлийн нөөцийг магадласан -ээр 148.18 мян.м<sup>3</sup> элс буюу хими цэврээр 57.37 кг алт болж байна. /Шлихээр 66.05 кг/. Хайлаастын орших хучаас хөрсөнд 0.1 м зузаан үе үлдээх, ул чулуулгаас мөн 0.1 м зузаан үеийг элстэй цуг сон бөгөөд эдгээр үеүд бохирдуулагч чулуулаг болно. Иймээс ордыг ашиглалтын үед хаягдалгүй

2014 оны 07-р сарын 03-ны ХХ-11-12 тоот дүгнэлт / тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашиггүй /- ай, 93.97 мян.м<sup>3</sup> хөрс, 3.44 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 0.64 кг алт , 2-В блокоос 4.66 мян.м<sup>2</sup> талбай, бай, 15.88 мян.м<sup>3</sup> хөрс, 0.60 мян.м<sup>3</sup> элс, хими цэврээр 0.10 кг алт тус блокуудаас хасагдана. Нийт 89 кг алт хасагдсан.

алаар залруулга хийхээр хүсэлт өгсөн.

**Танилцсан:**

АМГТГ-ын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн: ..... / Ц.Золзаяа /  
*25/7 2014*

тан /




ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН  
КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

## Кадастрын лавлагаа

## Лавлагааны мэдээлэл



Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-000296
Талбайн нэр	Хайлааст
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	228.21
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Ирмүүнбосго
Аймаг, сум, сав газрын нэр	Төв аймаг Заамар сум, Туул голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхацсан талаарх мэдээлэл	



### ТАНИХ ТЭМДЭГ





#### Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

-  Ашиглалтын
-  Хайгуулын


#### Засаг захиргааны хил

-  Улсын хил
-  Аймгийн хил
-  Сумын хил
-  Аймгийн төв
-  Сумын төв



#### Тусгай хамгаалалттай газар нутаг

-  Дархан цаазат газар
-  Байгалийн цогцолборт газар
-  Байгалийн нөөц газар
-  Дурсгалт газар

#### Хамгаалалтын бүсүүд

-  Гол мөрний урсац бүрэлдэх эх
-  Ойн сан бүхий газар

#### Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

-  Онцгой хамгаалалтын бүс
-  Энгийн хамгаалалтын бүс

#### Ус хангамжийн эх үүсвэр

-  Эрүүл ахуйн хориглолтын бүс
-  Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
-  Тэжээгдлийн муж

#### Орон нутгийн усны хамгаалалтын бүс

-  Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:29175




ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН  
КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

## Кадастрын лавлагаа

## Лавлагааны мэдээлэл

Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-019638
Талбайн нэр	Бумбат-6
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	515.06
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Ирмүүнбосго
Аймаг, сум, сав газрын нэр	Төв аймаг Заамар сум, Туул голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхацсан талаарх мэдээлэл	



## ТАНИХ ТЭМДЭГ

## Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

- Ашиглалтын
- Хайгуулын

## Засаг захиргааны хил

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв

## Тусгай хамгаалалттай газар нутаг

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар

## Хамгаалалтын бүсүүд

- Гол мөрний урсац бүрэлдэх эх
- Ойн сан бүхий газар

## Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

- Онцгой хамгаалалтын бүс
- Энгийн хамгаалалтын бүс

## Ус хангамжийн эх үүсвэр

- Эрүүл ахуйн хориглолтын бүс
- Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
- Тэжээгдлийн муж

## Орон нутгийн усны хамгаалалтын бүс

- Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:28741



MV-000296 тусгай зөвшөөрлийн талбайд нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах акт  
2023оны 10-дугаар сарын 11-ний өдөр

<i>1. Байршил мэдээлэл</i>		
1.1.	Аймаг, нийслэлийн нэр	Төв
1.2.	Сум, Дүүргийн нэр	Заамар
1.3.	Газрын нэр	“Хайлааст”
<i>2. Нөхөн сэргээлт хийсэн байгуулгын мэдээлэл</i>		
2.1	Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар	5396786
2.2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-000296
2.3	Тус талбайн нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ ( га )	
2.4	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	“Ирмүүнбосго”ХХК
<i>3. Өмнөх жилүүдэд тухайн тусгай зөврөөлтэй талбайн хийгдсэн нөхөн сэргээлтийн ерөнхий мэдээлэл</i>		
3.1	Техникийн нөхөн сэргээлт -Талбайн хэмжээ (26,04 га ) -Зардлын хэмжээ ( төгрөгөөр )	3.2 Биологийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ ( 39,07га ) -Зардлын хэмжээ ( төгрөгөөр )
<i>4. 2023онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл</i>		
Техникийн нөхөн сэргээлт -Талбайн хэмжээ ( га ) -Зардлын хэмжээ ( төгрөгөөр )	Биологийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ ( га ) -Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын нэр, ургамалжуулсан байдал ( Царгас-100кг Хошоон-100кг Хүцэнгэ-125кг Судан-120кг еөрхөг-60кг ботуул-50кг үүргэнэ-50кг 10.300.0 ) ( Улиас-4000ш, Хайлаас-5300ш 24.000.0 ) Хашаа- 400ш 30.000.0 Үрсэлгээ 1.590.0 -Зардлын хэмжээ ( төгрөгөөр )	
<i>5. Орон зай мэдээлэл</i>		
5.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг	5.2 Хэмжилт, зураглал -Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгуулга болон хэмжилт хийсэн хүний нэр: <b>М.Цогжавхаа</b> -Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж, -Холбогдох утас: Гарын үсэг:	

5.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол	№	Өргөрөг	Уртраг
	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт давхцуулсан		
	1	465314	5353396
	2	465275	5353341
	3	465358	5353284
	4	465434	5353234
	5	465483	5353183
	6	465532	5353212
	7	465391	5353441
	Биологийн нөхөн сэргээлт		
	1	464583	5354032
	2	464696	5354150
	3	464803	5354076
	4	464731	5353970
	Техникийн нөхөн сэргээлт		
	1	464459.00	5354063.05
	2	464376.73	5353993.91
	3	464455.22	5353874.53
	4	464555.78	5353907.81
	Нөхөн сэргээлт хийсэн хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр shape.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.		
<i>б. Мэдээллийн сангийн бүртгэл</i>			
Нөхөн сэргээлт хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн <a href="http://www.eic.mn">www.eic.mn</a> цахим системийн нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ. Жич:Мэдээллийн санд бүртгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй. Мэдээлэл оруулсан хүний нэр,албан тушаал: Гарын үсэг: Огноо:			
Нэмэлт мэдээлэл:			

Нөхөн сэргээлтийн ажил нь холбогдох хууль, журам стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт: .....

.....

.....

.....

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга:

.....

( гарын үсэг )

Ж.Даш-яйчил

( Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга )

Нарийн бичгийн дарга:

.....

.....

Гүйцэтгэх огноо / Value Date: ОН/МҮҮҮ      САР/ММ      ӨДӨР/ДД  
 2023      01      19

**Хүлээн авагчийн/Recipient's Information**

Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 100900013406		Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Банкны нэр / Bank name: Төрийн Сан
Валют / Currency: MNT	Дүн Тоогоор / Amount: *7,658,000.00*	Дүн үсгээр / Amount In words: *Долоон сая зургаан зуун тавин найман мянган төгрөг*	
Шилжүүлгийн утга / Description: MV-269 MV-019638 BOMT-50XUVB			Шилжүүлгийн дараалал / Transaction queue:

**Шилжүүлэгчийн / Sender's Information**

Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 5166952400		Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: ИРМИНБОСГО
Валют / Currency: MNT	Дүн Тоогоор / Amount: *7,658,000.00*	Дүн үсгээр / Amount In words: *Долоон сая зургаан зуун тавин найман мянган төгрөг*

**Хүлээн авагчийн / Receiver's Information**

IBAN: 100900013406 ✓	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: Валютын шилжүүлгийн хувьд латин үсгээр бөглөнө. For foreign currency transfer, the field to be filled in latin letters.	Банкны нэр / Bank name: Валютын шилжүүлгийн хувьд бөглөх шаардлагатай. For foreign currency transfer, bank name is required.
<b>Шилжүүлэгчийн болон шилжүүлгийн мэдээлэл / Sender and transaction's Information:</b>		
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 5166952400 ✓	Валют / Currency: MNT	Мөнгөн дүн / Amount: 7,658,000.00 ✓
Шилжүүлгийн утга / Description: MV-269 MV-019638 BOMT-50XUVB ✓		Гарын үсэг, тамга / Signature, stamp: 1. <i>[Signature]</i> ✓ 2. _____

Энэхүү баримтад бичигдсэн бүх мэдээлэл нь үнэн зөв болохыг дор гарын үсэг зурсанаар баталгаажуулж байгаа бөгөөд аливаа хуулийн хариуцлагыг хүлээхээ үүгээр хүлээн зөвшөөрч байна.  
 By signing in this form, I confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.

**Банкны тэмдэглэл/For Bank use only**

Хураамж/Fee amount:	Журнал №/Journal №: 26856721	Гарын үсэг/Signature:	Банкны ажилтан №/Bank staff №:	Огноо / Date: 2023/01/19	Шилжүүлэгчийн регистрийн дугаар / Customer ID: POID:000384052770
---------------------	---------------------------------	-----------------------	--------------------------------	-----------------------------	---

**ХААН БАНК**  
**21183-01**

ТГТ-ээр баталгаажсан эсэх: **гүй**



1.1. Худалдан авагч тал: Голомт Банк  
 1.2. Худалдагч тал: Ирмүүн босго ХХК  
 1.3. Орлого хүлээн авах Банк: Хаан  
 1.4. Регистр: 5396786  
 1.5. Угас: 99119472  
 1.6. Татвар: АМНАТ ӨН татвар  
 Алт: 5.0% 0.0%  
 Мөнгө: 5.0% 0.0%

№ 288

Ханшийн мэдээлэл

ОУЗУно - ам.доллар/унц:  
 Алт: 1,924.85  
 Мөнгө: 23.56  
 МБ-ны ам.дол/төгрөгийн албан ханш: 3,461.61  
 МБ-ны үнэт метал худалдан авах ханш:  
 Алт: 214,000.41  
 Мөнгө: 2,510.78  
 Нэмэгдэл:

1.7. Алт, мөнгөний тооцоо:

Д/д	Гулдмайн дугаар	Бохир жин /грамм/	Алтны сорьц	Мөнгөний сорьц	Алтны цэвэр жин	Трой Унц	Мөнгөний цэвэр жин	Нийт төлбөр	МӨН татвар	АМНАТ	Харилцагчид олгох дүн
1	56	3,216.80	907.00	87.00	2,917.35	93.79	279.58	625,016,059.98	-	31,250,803.00	593,765,256.98
2											
3											
4											
5											
6											
7											
8											
9											
10											
	Нийт	3,216.80			2,917.35	93.79	279.58	625,016,059.98	-	31,250,803.00	593,765,256.98

1.8. Төлбөр, тооцоо:


Дт 110 010 0100 625,016,059.98  
 Кт 116 511 7377 31,250,803.00  
 Кт 512 903 0603 593,765,256.98

Алт 624,314,096.11 31,215,704.81  
 Мөнгө 701,963.87 35,098.19

ТТД NA  
 Хаан банк дахь Ирмүүн босго ХХК-ийн төгрөгийн дансанд  
 Голомт банкнаас алт, мөнгөний үнэ шилжүүлэв.

ГОЛОМТ БАНКЫГ ТӨЛӨӨЛЖ

Төв БТ-н харилцааны менежер /алт/



ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Ирмүүн босго ХХК



БАТЛАВ  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.НЯМДОРЖ

2023 оны 05 дугаар сарын 8.

БАТЛАВ  
УЛААНБААТАР ХОТ  
"ИРМҮҮН БОСГО" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Х.ЦОГОО

2023 оны 05 дугаар сарын ....

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 23/15

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, "Усны газар"-ын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 05/484 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 84 "Ус ашиглуулах дүгнэлт", Туул голын сав газрын захиргааны даргын 2023 оны 05 дугаар сарын 8-ны өдрийн А/24 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, нефтийн 1-11 тоот, Улсын бүртгэлийн 901124141 тоот гэрчилгээ, 5396786 регистрийн дугаартай "Ирмүүн босго" ХХК-ийн геологич Х.Баасанхүү нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 *Ус ашиглах зориулалт:* Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296, MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хайлаастын амны алтны шороон орд"-ын үйлдвэрлэл технологийн хэрэгцээнд гүний худаг болон уурхайн шүүрэлтийн уснаас ашиглана.

2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.4-т заасны дагуу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 3'070.0 м<sup>3</sup> элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах ус 47'824.5 м<sup>3</sup>/жил;

2.2.1. Унд ахуйд ашиглах ус: 319.5 м<sup>3</sup>/жил;

2.2.2. Уурхайн ухлагаас шавхан зайлуулж ашиглах газрын доорх ус: 11'958.0 м<sup>3</sup>/жил;

2.2.3. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах газрын доорх ус: 35'547.0

м<sup>3</sup>/жил;

2.3. *Усны чанар, найрлага:* 2023 оны 06, 09, 11 дүгээр сард хаягдлын нуурын уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Технологийн болон бусад хэрэглээний усыг гүний 2 худгаас авч ашиглана. Худгийн байршлын солбицол: 48° 19'53.88", 104° 31'57.68", 48° 19'53.34", 104° 32'00.45".

2.4.2. *Барилга байгууламж:* 0.77 га талбайг хамарсан 2 тунаах нууртай. Нуурын нийт талбай 1.9 га.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк:* Уурхайн олборлолтод ажиллуулах техник: hyuandai R850LC маркийн эксковатор 4 ш, hyuandai R520LC маркийн эксковатор 2 ш, caterpillar D8 маркийн бульдозер 2 ш, liugong SDLG953 маркийн утгуурт ачигч 2 ш, СБ-80 маркийн хүрдэт шигшүүр 2 ш, YLG-45 маркийн хоригт цорго 2 ш, 6-S 7.6 маркийн сэгсрэх ширээ 2 ш тус тус ашиглана.

2.4.4. *Насосны хүчин чадал:* Эргэлтийн ус болон технологийн усны насос Y280S-4 маркийн, 80 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай.

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:* Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг мөрдлөг болгоно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:*

2.6.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу төлбөр тооцно.

2.6.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайд 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам"-ын дагуу тохижуулж ашиглана.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:*

2.7.1. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах.

2.7.2. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 5.0 га талбайд хийнэ. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 ш талбайд мод тарина.

2.8. *Усны тоолуур:* Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллана. Унд ахуйн худагт тоолуур суурилуулж тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.8.1. Гэрээнд заагаагүй эх үүсвэрээс ус ашигласан нөхцөлд угаасан элсний хэмжээг уулын ажлын тайланг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайд 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын дагуу ашигласан усны зарцуулалтын хэмжээг тооцно.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.9.1. Ашигт малтмал олборлон, баяжуулахад ашиглах 35'547.0 м<sup>3</sup> газрын доорх усны төлбөрт 93'957'830.0 /Ерэн гурван сая есөн зуун тавин долоон мянга найман зуун гучин/ төгрөг, уурхайн шүүрлээс шавхан зайлуулж ашиглах 11'958.0 м<sup>3</sup>/жил газрын доорх усны төлбөрт 11'852'770.0 /Арван нэгэн сая найман зуун тавин хоёр мянга долоон зуун далан/ төгрөг, нийт 105'810'600.0 /Нэг зуун таван сая найман зуун арван мянга зургаан зуун/ төгрөгийг Төв аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 40 хувийг хоёрдугаар, 60 хувийг гуравдугаар улиралд төлнө.

2.9.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

2.9.3. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-д заасны дагуу төлбөр тооцно.

### Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн оны эхний улиралд багтаан байгуулна.

4.3. Тайлант оны уулын ажлын гүйцэтгэлийн тайлан, ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн баталгаажуулах бөгөөд гэрээнд заасан төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж буй усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;


4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
албаны дарга



П.ЭНХБАЯР

Хүн ам, хот суурины ус хангамжийн  
ашиглалтын асуудал хариуцсан  
мэргэжилтэн



Э.МЯГМАРСҮРЭН

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,  
2-р хороо, Чингүнжавын гудамж,  
Туул голын сав газрын захиргааны  
байр, 203 тоот өрөө.  
Харилцах утас: 7000-3716, 7000-3714.

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Ирмүүн босго” ХХК-ийн геологич



Х.БААСАНХҮҮ

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан  
дүүрэг, 20-р хороо, нефтийн 1-11 тоот.

Харилцах утас: 9911-9472, 9923-7467



ТУУЛ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 24 дугаартай албан бичиг, "Усны газар"-ын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 05/484 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 84 "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


НЭГ. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000296, MV-019638 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хайлааст"-ын амны алтны шороон ордоос 3'070.0 м<sup>3</sup> элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэгцээнд шаардагдах 11'958.0 м<sup>3</sup> усыг уурхайн ухлагад шүүрэн орж ирэх, 35'547.0 м<sup>3</sup> газрын доорх уснаас, унд-ахуйн хэрэглээний 319.5 м<sup>3</sup> усыг өөрийн эзэмшлийн гүний 2 худгаас 2023 онд ашиглахыг "Ирмүүн босго" ХХК-д зөвшөөрсүгэй.

ХОЁР. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах алба /П.Энхбаяр/, Туул голын сав газрын захиргааны менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Жаргал/ нарт үүрэг болгосугай.

ГУРАВ. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг "Ирмүүн босго" ХХК /Х.Цогоо/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НЯМДОРЖ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**УСНЫ ГАЗАР**

Чингунжавын гудамж, 2 дугаар хороо,  
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050  
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,  
Цахим шуудан: office@water.gov.mn,  
Цахим хуудас: www.water.gov.mn

2023.05.03 № 05/484  
танай 2023.04.12 ны № 17 -т

**"ИРМҮҮН БОСГО" ХХК-Д**

Танай байгууллагын 2023 оны 14 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заасны дагуу Төв аймгийн Заамар сумын нутагт хэрэгжиж байгаа ашигт малтмалын үндсэн MV-019638, нэмэлт MV-000296 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий "Хайлаастын доод хэсэг, дэнжийн хэсэг, доод хэсгийн, зүүн борт, хайлаастын хөндийн зүүн салаа жалга-3, жалга-4 нэртэй алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах төслийн ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Туул голын сав газрын захиргаанд  
Хавсралт: 6 хуудаастай.

УС АШИГЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



У.ӨЛЗИЙЦЭЦЭГ

162331245

Улаанбаатар хот  
Утас: 51-265530

**УСНЫ БҮРТГЭЛИЙН БОЛОН**

гар хот, Сонгино хайрхан  
467, 9901-1717, И-мэйл:  
141, регистрийн дугаар:

"Хайлааст" нэртэй газарт  
угаартай ашигт малтмал  
нь Улаанбаатар хотоос  
йш 25 км зайд байрладаг.

720-722, 14-16), дэнжийн  
га-4, Хайлаастын алтны  
3 шугам хоорондох алтны  
24-40), зүүн борт хэсгийн  
н алтны шороон орд" гэх).

С/У/

и тусгай зөвшөөрлийг анх  
зөвшөөрлийг 2017.10.05-  
эр "Ирмүүнбосго" ХХК-д

1 га (Солбилцлын 36 цэг).

Өргөрөг
48°19'55.73"
48°19'55.68"
48°20'2.16"
48°20'2.12"

5	104°30'52.91"	48°20'19.63"	23	104°32'5.81"	48°20'11.82"
6	104°31'2.61"	48°20'19.67"	24	104°31'48.83"	48°20'11.76"
7	104°31'2.7"	48°20'11.57"	25	104°31'48.76"	48°20'18.24"
8	104°31'24.55"	48°20'11.65"	26	104°31'36.62"	48°20'18.19"
9	104°31'24.6"	48°20'5.18"	27	104°31'36.58"	48°20'23.03"
10	104°31'22.17"	48°20'5.18"	28	104°31'25.66"	48°20'22.99"
11	104°31'22.27"	48°19'55.46"	29	104°31'25.6"	48°20'27.87"
12	104°31'41.69"	48°19'55.54"	30	104°31'24.39"	48°20'27.85"



2023 онд 71 хүн хоногт 2 ээлж 20 цагаар, 240 хоног ажиллана. Элс угаах 1 төхөөрөмж (скруббер)-ийн цагийн хүчин чадал 80.0 м<sup>3</sup> (2023 оны АҮАТ-ний 25х, Маягт-7).

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ**

2023 онд 63.11 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 3.07 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулж, 3.23 кг алт гарган авна. Биологийн нөхөн сэргээлтийг 5.0 га-д хийж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 ш мод тарина.

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.мөтрээр/**

Унд, ахуйн усыг өөрийн эзэмшлийн уурхайн талбайд гаргасан өрөмдмөл худгаас, технологийн болон бусад хэрэглээний усыг өрөмдмөл худаг, шүүрлийн уснаас хангадаг.

